

**11-Р АНГИЙН БИОЛОГИ ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН ДААЛГАВАР**

Анги ... бүлэг ...

Сурагчийн нэр .....

Хугацаа: 60 минут

**ХУВИЛБАР А****НЭГДҮГЭЭР ХЭСЭГ**

- Уургийн молекулын мономерыг сонгоорой 1оноо  
А. Глюкоз б. Аминхүчил в. Тосны хүчил г. Бүгд зөв
- Их хэмжээний дулаан ялгаруулж задрах шинж нь уургийн биологийн ямар үүрэг вэ? 2оноо  
А. Бүтцийн б. Энергийн в. Каталитик үүрэг г. Хамгаалах үүрэг
- Эсийн доторх олон янзын химийн урвал нь энзим хэмээх биологийн катализаторын тусламжтайгаар явагддаг нь уургийн биологийн аль үүрэг вэ? 1оноо  
А. Бүтцийн б. Энергийн в. катализаторын г. Хамгаалах
- Олон тооны аминхүчлүүд өөх хоорондоо карбоксил бүлэг, амин бүлгээрээ холбогдож полипептид холбоо үүсгэсэн макромолекулыг .....уургийн анхдагч бүтэц гэнэ.
- Энзимийг бүтээгч бодис аль нь вэ? \1оноо\  
А. Нүүрс ус б. Өөх тос в. Нуклеотид г. Уураг
- Амьтны эсэд байдаг нянд байдаггүй эрхтэнцрийг олж тэмдэглээрэй. \1оноо\  
А. Цитоплазм б. Плазман мембран в. Митохондри г. Рибосом
- Ус түүнд ууссан давс, нөөц бодис хадгалагдах тул эсийн осмосын үзэгдлийг барьдаг. Эсийн бодисын солилцоо явагддаг эрхтэнцрийг сонгоно уу? \1оноо\  
А. Вакуоль б. Митохондри в. лизосом г. Хлоропласт
- Эукариот эсийн эрхтэнцрүүдийг гүйцэтгэх үүрэгтэй нь сумаар холбоно уу? \1оноо\  
А. Хлоропласт 1. Удамшлын мэдээллийг хадгална  
Б. Митохондри 2. Гэрэл нийлэгжилт явуулна  
В. бөөм 3. Аэроб амьсгал явагдаж, энерги үүснэ  
А. А162в3 б. А263в1 в. А362в1
- Эсийн энергийн төв болдог. Аэроб амьсгал явагддаг. Дотоод мембран дээр ус, энерги ялгарна. \1оноо\  
А. Бөөм б. Вакуоль в. митохондри г. Эсийн бүрхүүл
- ДНХ нийлэгжин, хромосом хос хроматидаас тогтдог үйл явц эсийн хуваагдлын аль үе шатанд явагдах вэ? \1оноо\  
А. S үе шат б. G1 үе шат в. G2 үе шат г. Митоз
- Цитокинез гэдэг нь ..... \1оноо\  
А. Бөөмийн хэваагдал б. Эсийн мембраны хуваагдал в. Цитоплазмын хуваагдал  
г. Хромосомын хуваагдал
- Сонгины үрэвчинд үүссэн зигот 20 хромосомтой бол навчны эсүүдийн хуваагдлын үеийн хроматидын тоо хэд вэ? \1оноо\  
А. 4 б.20 в.10 г.15
- ДНХ-ын репликац эсийн мөчлөгийн аль үе шатанд явагдах вэ? \1оноо\  
А.интерфаз үе шат б. Профаз үе шат в. Метафаз үе шат г. Анафаз үе шат
- Мэдээллийн РНХ нь бөөмд байгаа удамшлын мэдээлэл болох тухайн нийлэгжих уургийн мэдээллийг ДНХээс хуулбарлан эсийн сийвэнд хүргэнэ. Ингэж ДНХийн мэдээллийг мэдээллийн РНХ өөртөө буулган нийлэгжихийг.транскрипц.....гэнэ. 2 оноо
- Рибосом нь уургийг нийлэгжүүлэгч гол эрхтэнцар бөгөөд рибосом дээр мэдээллийн РНХ ийн кодын дагууд тохирох амин хүчлүүд хоорондоо холбогдон анхдагч бүтэцтэй уургийн молекул үүсэхийг юу гэдэг вэ? 1 оноо  
А. Транскрипц б. Трансляц в. полисом г. Триплет
- Амсрын эсийн бүтэц үүргийн зөв хариултыг сонго. 1 оноо  
А. Амсар нь 2 саран хэлбэрийн эс, жигд зузаан эсийн ханатай ханатай,хлоропластын мөхлөгтэй  
Б. Амсар нь 3 саран хэлбэрийн эс, жигд бус зузаан эсийн ханатай, хлоропластын мөхлөггүй  
В. Амсар нь 2саран хэлбэрийн эс, жигд бус зузаан эсийн ханатай , хлоропластын мөхлөггүй  
Г. Амсар нь 2 саран хэлбэрийн эс, жигд бус зузаан эсийн ханатай, хлоропластын мөхлөгтэй
- Модлог ургамлын ишны багцын бүтцыг зөв дарааллуулсныг ол. 1оноо

А.гол,модлог,долон,золон,илчүү б.гол,модлог,золон,долон,илчүү в.гол,золон,модлог,долон,илчүү г.гол,долон,модлог,золон,илчүү

18. Зууван эсүүдтэй, уулзварын хэсэгтэй шигшүүрт илтэс үүсгэсэн,шим тэжээлийн бодисыг уруудах чиглэлд зөөнө. 1оноо

А.Цорго б. Шигшүүрт хоолой в. илчүү г. Модлог

19. Зүрхний .....нь зөвхөн уушгинаас, уушгины венийн судсаар урсан ирж буй цусыг хүлээж авдаг. 1оноо

А. Зүүн тосгуур б. Баруун тосгуур в. Зүүн ховдол г.Баруун ховдол

20. Фагоцит мэтийн зарим цагаан эс бактерийг залгин боловсруулах аргаар устгах бөгөөд энэ үйл явцыг ..... гэдэг. 1оноо

А.пиноцитоз б.фагацитоз в.фагорин г.пинорин

21. Зөв харгалзуулсан хувилбарыг ол. 2 оноо

1. улаан эс а. Бөөмтэй,гадны элдэв өвчин үүсгэгчдээс хамаалах

2. цагаан эс б. Бөмгүй, хүчилтөрөгчөөр баялаг

3. ялтас в. бөөмгүй,цус бүлэгнэх төлжүүлэхэд гол үүрэгтэй

А.1В2А3Б б.1В2В3А в.1В2А3В г.1В2Б3А

22. Цусны ялтас эсийн амьдрах хугацаа хэд вэ? 1оноо

А. 5-8 хоног б. 8-10 хоног в. 14 хоног г. 21 хоног

23. Хүчилтөрөгч бага нүүрсхүчлийн хий ихтэй цусыг юу гэдэг вэ? 1оноо

А. Артерийн цус б. Венийн цус в. цус багадах г. Цусны эс

24. Агаар дамжуулах хэсгийн бүтцийг зөв дарааллуулсныг ол. 1оноо

А. Хамрын хөндий, төвөнх, мөгөөрсөн хоолой, гуурсан хоолой, уушги

Б. Хамрын хөндий,төвөнх,гуурсан хоолой,мөгөөрсөн хоолой,уушги

В. Хамрын хөндий,гуурсан хоолой,төвөнх,мөгөөрсөн хоолой,уушги

Г. Хамрын хөндий,төвөнх,улаан хоолой,гуурсан хоолой,уушги

25. Тайван байдлаар амьсгал гаргахад уушгинд үлдэх нөөц агаарыг ..... гэнэ. 1оноо

А. Уушгины агаар б.цулцангийн агаар в.ашиггүй агаар г.уушгины агааржуулалт

26. Зөв харгалзуулна уу? 2оноо

1. халдварт бус өвчин

а. Өвөрмөц үүсгэгчээр үүсгэгдэж, халдвар тараадаг,үечилсэн явцтай, өвөрмөц дархлаа тогтдог, өргөн хүрээний бүлэг өвчин

2. халдварт өвчин

б. Энэ бол хүний эс үржиж хуваагдах, ялгарах зэрэг хэвийн үйл ажиллагааны бүтцээ алдаж өөрчлөгдсөнмий улмаас үүссэн хэт ургалт юм

3.хавдар

в. бие мхбодын бүтэц зүйн хэвийн байдал алдагдах ба бусад биед ямар нэгэн замаар халдварлахгүй тухайн бодгаль өвчилдөг

а.1В2А3В б.1А2В3Б в.1В2Б3А г.1В2А3Б

27. Урвах тахал буюу холерийн үүсгэгчийг олно уу? 1 оноо

А. Нян б. Вирус в. мөөгөнцөр г. Эгэл биетэн

28. Хүний биеийн жингийн үзүүлэлтээр таргалалтын хэлбэрийг 6 ангилдаг. Илүүдэл жингийн индексийн үзүүлэлтийг олно уу? 1оноо

А. 18.5 б. 25-29.9 в. 30-34.9 г. 40өөс дээш

29. Цус бүлэгнэх үед мөн эсрэгтөрөгч ба эмгэг төрөгчийг үүсэхэд идэвхжин үрэвслийн медиаторууд ялгаруулдаг цусны эсийг дугуйлна уу? 1 оноо

А. Улаан эс б. Цагаан эс в. ялтас эс г. Сийвэн

30. Эмчилгээний ийлдэс хийсний дараа тогтсон дархлааг ..... гэнэ. 1оноо


А. Вакцинжуулалт б. Идэвхгүй дархлаа в. идэвхитэй дархлаа г. Олдмол дархлаа

### ХОЁРДУГААР ХЭСЭГ

1. ДНХ, РНХ-ийн үндсэн ялгааг нөхөж бич. \3оноо \

№	Ялгаа	ДНХ	РНХ
1	Азотлог суурь	АГЦТ	
2	Нүүрс ус		рибоз
3	Полипептидийн гинжны тоо	2	
4	Байрлал	бөөмөнд	
5	Биологийн үүрэг	Их	Бага


2. Эсийн органиодын сумаар заасан бүтцийг нэрлэнэ үү?. 3оноо



3. Дараах эсийн эрхтэнцрийг нэрлээд үүргийг бичээрэй. Зоноо



4. Эсийн митоз хуваагдлын зургийг ажиглан метафаз үе шатыг тайлбарлаарай. Зоноо



5. Уургийн бүтцийн сумаар заасан хэсгийг нэрлээрэй. 3 оноо

